



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/117

Даланзадгад

Хуваарь, чиг үүрэг батлах тухай

Эрүүл Мэнд, Спортын Сайдын 2016 оны А/204, Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны А/88, Эрүүл Мэндийн Сайдын 2020 оны А/222, Эрүүл Мэндийн Сайдын 2020 оны А/318 дугаар тушаалуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эх барих эмэгтэйчүүдийн эмч нар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хариуцан ажиллах хуваарь, ажлын чиг үүргийг нэгдүгээр, хүүхдийн эмч нар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хариуцан ажиллах хуваарь, ажлын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах олон талт ажлуудыг санаачлан хэрэгжүүлж, мэргэжлийн арга зүйгээр ханган, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст тайлагнаж ажиллахыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хариуцан ажиллаж байгаа нарийн мэргэжлийн эмч нарт даалгасугай.

3. Зөвлөх чиг үүрэг бүхий эмч нарын зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, мэргэжлийн зөвлөгөө туслалцаа тогтмол авч, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд хамтарсан ажиллаж, тусламж үйлчилгээнд чанарын дэвшил гарган ажиллахыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн арга зүй, дэмжлэгт удирдлагаар ханган, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Ж.Отгонбайгал/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

C:\Desktop\2020 on TUSHAAL

461200277

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
А/117 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

I. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧ НАР АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ, АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

1.1. АЖИЛЛАХ ХУВААРЬ

| № | Овог, нэр | Ажлын газар, албан тушаал | Утасны дугаар | Эрүүл мэндийн байгууллагын нэр |
|----|----------------|--|----------------------|---|
| 1 | Д.Түвшинзул | БОЭТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга | 99073855 88703855 | Сэврэй СЭМТ |
| | Д.Алтансүх | Сэврэй СЭМТ-ийн дарга, эх барих эмэгтэйчүүдийн эмч | 88709986 | |
| 2 | Б.Мөнхбат | БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч | 99539435 88539435 | Энхийн хүслэн ӨЭМТ, Мандал-Овоо СЭМТ |
| 3 | Д.Отгонжаргал | БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч | 86064686 | Гурван тэс СЭМТ |
| 4 | Ө.Батцэцэг | БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 88058104 | Шим билэг ӨЭМТ, Ханхонгор СЭМТ |
| 5 | Т.Пүрэврагчаа | БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 96039493 80039493 | Өнө-Орших ӨЭМТ, Ноён СДЭ |
| 6 | Б.Сэлэнгэ | БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 86085507 | Баяндалай СЭМТ, Цогт-Овоо СЭМТ |
| 7 | Б.Цэцэгбадам | БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 88368020 | Хүрмэн СЭМТ |
| 8 | Б.Үүрийнцолмон | Цогтцэций СДЭ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 88035510 | Цогтцэций СДЭ, Манлай СЭМТ |
| 9 | Д.Өлзийсайхан | Ханбогд СДЭ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 89242399 | Ханбогд СДЭ |
| 10 | Э.Дөлгөөн | Ханбогд СДЭ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 88550955 | Баян-Овоо СЭМТ |
| 11 | Б.Долгормаа | Булган СЭМТ-ийн дарга, эх барих эмэгтэйчүүдийн эмч | 88875667 | Булган СЭМТ |
| 12 | Б.Батчимэг | Номгон СЭМТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч | 88601242 | Номгон СЭМТ |

1.2. АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

1.2.1 Харьяаллын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд тэр дундаа эрсдэлтэй бүлгийн эмэгтэйчүүдийн судалгаанд дүгнэлт хийж, эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллахад дэмжлэг үзүүлэх;

1.2.2 Эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаалыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

1.2.3 Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламжийн зохион байгуулалтын болон мэргэжлийн тусламжийг үзүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад санаачилгатай ажиллах, эмнэлзүйн зөвлөгөө зөвлөмжийг телемедицини ашиглан, зайн оношилгоо, зөвлөгөөг эрчимжүүлж ажиллах;

1.2.4 Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны болон цахим сургалт зохион байгуулах;

1.2.5 Эх барих эмэгтэйчүүд, нярайн нэн шаардлагатай болон яаралтай тусламжийн байнгын бэлэн байдал эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн хүрэлцээ, чадавхыг үнэлж, орон нутгийн шийдвэр гаргагчдад танилцуулж, асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

1.2.6 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ (үр хөндөлт, гэр бүл төлөвлөлт, БЗДХ, өсвөр үе, цэвэршилтийн нас)-нд үнэлгээ хийж, зөвлөгөө өгөх;

1.2.7 Хариуцсан анхан шатны эрүүл мэндийн төвийн жирэмсний хяналт хариуцсан эмч, эх баригчтай байнгын уялдаа холбоотой ажиллаж, зөвлөгөө өгөх;

1.2.8 Үйлчлүүлэгчийг дээд шатлалд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

1.2.9 Хариуцсан сүм, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр бичиж, Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст ирүүлэх;

1.2.10 Үр дүнтэй ажиллаж, тухайн эрүүл мэндийн байгууллагын статистик үзүүлэлтэд ахиц дэвшил гаргасан эмч нарыг Эрүүл мэндийн газрын удирдлагын багийн шийдвэрээр урамшууллын саналыг өөрийн байгууллагад нь хүргүүлж ажиллана.

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
A/117 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

II. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮҮХДИЙН ЭМЧ НАР АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ, АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

2.1 АЖИЛЛАХ ХУВААРЬ

| № | Овог, нэр | Ажлын газар, албан тушаал | Утасны дугаар | Эрүүл мэндийн байгууллагын нэр |
|----|----------------|--|---------------|---------------------------------------|
| 1 | Т.Оюундүү | БОЭТ-ийн захирал, хүүхдийн ерөнхий мэргэжилтэн | 99100285 | Өнө-Орших ӨЭМТ |
| | Ж.Мөнхцэцэг | Өнө-Орших ӨЭМТ-ийн дарга, хүүхдийн эмч | 88323086 | |
| 2 | Ц.Мөнхцэцэг | БОЭТ-ийн хүүхдийн тасгийн эрхлэгч | 88407289 | Энхийн хүслэн ӨЭМТ |
| 3 | Д.Саранчимэг | БОЭТ-ийн хүүхдийн эмч | 88562159 | Баян-Овоо СЭМТ, Цогт-Овоо СЭМТ |
| 4 | С.Алтанцэцэг | БОЭТ-ийн нярайн тасгийн эрхлэгч | 88054896 | Мандал-Овоо СЭМТ |
| 5 | Б.Одцэцэг | БОЭТ-ийн нярайн эмч | 88038209 | Номгон СЭМТ |
| 6 | Э.Ренчин | БОЭТ-ийн нярайн эмч | 88464499 | Сэврэй СЭМТ |
| 7 | Ө.Оюунчимэг | БОЭТ-ийн нярайн эмч | 88023708 | Гурвантэс СЭМТ |
| 8 | С.Насантогтох | БОЭТ-ийн өсвөр үеийн кабинетын эмч | 86660074 | Ханхонгор СЭМТ |
| 9 | Ж.Наранцэцэг | Ханбогд СДЭ-ийн хүүхдийн их эмч | 89991329 | Ханбогд СДЭ |
| 10 | Ж.Мягмарцэрэн | Баяндалай СЭМТ-ийн дарга, хүүхдийн их эмч | 89897089 | Баяндалай СЭМТ |
| 11 | Ц.Бурмаа | Ноён СДЭ-ийн хүүхдийн эмч | 96061736 | Ноён СДЭ |
| 12 | Б.Бат-Өлзий | Шим билэг ӨЭМТ-ийн хүүхдийн их эмч | 88085108 | Шим билэг ӨЭМТ |
| 13 | Б.Туул | Хүрмэн СЭМТ-ийн дарга, хүүхдийн эмч | 88079104 | Хүрмэн СЭМТ |
| 14 | Д.Уламбаяр | Манлай СЭМТ-ийн хүүхдийн эмч | 88024435 | Манлай СЭМТ |
| 15 | Ц.Нармандах | Булган СЭМТ-ийн хүүхдийн эмч | 88170919 | Булган СЭМТ |
| 16 | Э.Оюунтунгалаг | Энэрэхүй ухаан ӨЭМТ-ийн дарга, хүүхдийн эмч | 88954045 | Цогтцэций СДЭ, Энэрэхүй ухаан ӨЭМТ |

2.2 АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

2.2.1 0-5 настай хүүхдийн бүртгэл судалгаа, тэр дундаа эрсдэлтэй бүлгийн хүүхдийн нарийвчилсан судалгаанд дүгнэлт хийж, эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллахад дэмжлэг үзүүлэх;

2.2.2 Хүүхэд, нярайн тусламж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаалыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

2.2.3 Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхэд, нярайн тусламжийн зохион байгуулалтын болон мэргэжлийн тусламжийг үзүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад санаачилгатай ажиллах, эмнэлзүйн зөвлөгөө зөвлөмжийг телемедицини ашиглан, зайн оношилгоо, зөвлөгөөг эрчимжүүлж ажиллах;

2.2.4 Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны болон цахим сургалт зохион байгуулах;

2.2.5 ХӨЦМ, эрэмбэлэн ангилал, нярайн нэн шаардлагатай болон яаралтай тусламжийн байнгын бэлэн байдал эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн хүрэлцээ, чадавхыг үнэлж, орон нутгийн шийдвэр гаргагчдад танилцуулж, асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.6 Хариуцсан анхан шатны эрүүл мэндийн төвийн хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэнд хариуцсан эмчтэй байнгын уялдаа холбоотой ажиллаж, зөвлөгөө өгөх;

2.2.7 Үйлчлүүлэгчийг дээд шатлалд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

2.2.8 Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр бичиж, Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст ирүүлэх;

2.2.9 Үр дүнтэй ажиллаж, тухайн эрүүл мэндийн байгууллагын статистик үзүүлэлтэд ахиц дэвшил гаргасан эмч нарыг Эрүүл мэндийн газрын удирдлагын багийн шийдвэрээр урамшууллын саналыг өөрийн байгууллагад нь хүргүүлж ажиллана.